

ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН



2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын өрийг барагдуулах жил” болгон зарласантай холбогдуулан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд байцаагч ажилтнуудын мэдлэг чадвар, бүтээлч сэтгэлгээ, идэвх оролцоог нэмэгдүүлэх замаар даатгуулагчид үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээний чанар, үр нөлөөг дээшлүүлэх, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, нийгмийн даатгалын хуримтлагдсан өр, авлагыг барагдуулах зорилтыг ханган ажиллалаа.

НЭГ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

1.1. Хүний нөөцийн талаар

НДЕГ-ын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/51 дугаар тушаалаар батлагдсан 50 орон тоонд багтаан үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд шилжүүлэн томилогдсон 5, ажлаас чөлөөлсөн 3, түр орлон гүйцэтгэх 5 нийт 13 албан хаагчийг томилж чөлөөлөхдөө төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн. Одоо нөхөгдөөгүй байгаа албан тушаалын 3 сул орон тооны мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.

Үүнд газрын 2 орон тоо, Яруу сумын Нийгмийн даатгалын байцаагч, мэргэжилтний 1 болно. Дээрх суманд газарт тэтгэврийн тогтоолт олголтын байцаагч, мэргэжилтнээр шилжин ажилласан байцаагчийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон бусад холбогдох байгууллагуудад хүний нөөцтэй холбоотой 9 судалгааг гаргаж хугацаанд нь хүргүүлж ажилласан.

2024 оны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргавал зохих 25 ажилтнаас хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд нь 100% гаргуулан авч нэгтгэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

Сэлгэн болон шилжин ажиллах 5 ажилтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргуулан Авлигатай тэмцэх газраар хянуулан томилон ажиллуулсан.

Ажилтан албан хаагчдын гаргасан ашиг сонирхлын мэдэгдэл тайлбарыг meduuleg.iaac.mn болон shilendans.gov.mn сайтад тухай бүр байршуулсан

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Аймгийн засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг хүргүүлсэн.

1.2 Бичиг хэрэг, архивын талаар

Сумдын нийгмийн даатгалын тасгаас 297 тэтгэврийн хувийн хэрэг, эмнэлгийн хуудас, тэтгэмжийн материал, шимтгэлийн болон бусад бичиг ирснийг бүртгэж хүлээн авсан, газрын байцаагч, ажилтнуудаас 114 албан бичиг болон бусад бичиг баримт бичгийг сумдад хүргүүлсэн байна.

НДЕГ-аас ирүүлсэн хугацаатай 39 бичгийг хугацаанд нь шийдвэрлэн холбогдох байгууллагад хүргүүлсэн. Сумдын байцаагчдад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах 27 удаагийн зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

Аймгийн ЗДТГ-аас болон бусад байгууллагаас ирүүлсэн 198 тушаал, албан бичиг, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЗДТГ-аас хэлтэс агентлагийн дарга нарт зохион байгуулдаг шуурхай хурлын 2 удаагийн мэдээллийг ажилтнуудад хүргэн, цаг үеийн чухал ажлын талаар мэдээлэл хүргэх зорилгоор сумдын байцаагчдад ZOOM программаар, газрын байцаагчдад танхимаар мэдээллийн цагийг 3 удаа зохион байгуулж, арга зүйгээр ханган ажилласан.

2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэд, даатгуулагчдаас 86 өргөдөл гомдол хүлээн авснаас 76 шийдвэрлэж, 10 өргөдөл шийдвэрлэх хуулийн хугацаанд байгаа талаар мэдээ тайланг холбогдох журмын дагуу гаргасан. Үүнээс 11-11 төвөөс шилжүүлэн ирсэн өргөдөл 6, талархал 1 байна.

НДЕГ-т сар бүрийн 10-ны өдрийн дотор НДЕГ-т өргөдөл гомдлын мэдээг хүргүүлж, тайланг 1 удаа хүргүүлэн ажилласан.

“Албан хэрэг хөтлөлтийн явцад үүссэн баримтын архивт хүлээн авах хуваарь”-ийг гаргаж газрын даргын 2025.01.27-ны өдрийн А/05 тоот тушаалаар баталж хэрэгжүүлэн ажилласан. Үүнд: 2024 оны НДШ 44, СДД-ын 64, түр хадгалагдах 66, байнга хадгалах 16 хадгаламжийн нэгжийг архивласан.

Аймаг дүүргүүдэд архивын лавлагаа авахаар хүргүүлсэн 93 хүсэлтийн хариуг хүлээн авч цахимаар 110 лавлагааг солилцож, иргэд даатгуулагчдад олгосон байна.

Дотооддоо иргэд даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 165, аж ахуй нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн 75, АЖТДШНТухай хуульд хамрагдсан 36, QR-кодоор 193, нийт 469 лавлагааг иргэд даатгуулагчдад олгосон.

Тэтгэвэр авч байгаад нас барсан, зогсоогдсон 76 тэтгэврийн хувийн хэргийн баримтын бүрдлийг мэдээллийн баазтай тулган шалгаж архивт шилжүүлсэн.


Газрын даргын 2025.05.14-ний өдрийн А/30 тоот тушаалаар “Баримт нягтлан шалгах комисс”-ыг шинэчлэн байгуулсан. Уг комисс нь 1 удаа хуралдан тус газрын 2025 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг хянан хэлэлцэн газрын даргаар батлуулсан ажилласан.

1.3 Засгийн газрын шийдвэрийн дагуу зохион байгуулсан ажлын талаар

Засгийн газрын тогтоол-1, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал -2, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар-1, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 23 тушаал ирсэн бөгөөд тухай бүр хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Аймгийн ЗДТГ-аас болон бусад байгууллагаас ирүүлсэн 198 тушаал, албан бичиг, тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж ирсэн чиглэл, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд нэг мөр ойлголт өгөх, аймгийн ЗДТГ-аас хэлтэс агентлагийн дарга нарт зохион байгуулдаг шуурхай мэдээллийг хүргэх, цаг үеийн чухал ажлын талаар мэдээлэл хүргэх зорилгоор сумдын байцаагчдад ZOOM программаар, газрын байцаагчдад танхимаар мэдээллийн цагийг 3 удаа зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

1.4 Газрын дотоод ажлыг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажлын талаар

1. “Цахим хөтөч”-ийг газрын үйлчилгээний зааланд байрлуулж иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажиллаж байна.



2. Газрын ажилтнууд ажлын байранд нийгмийн даатгалын лого бүхий цагаан болон ногоон өнгийн Поло футболкоор жигдрэн иргэдэд үйлчилгээ үзүүлж, эв нэгдэл сэтгэл ханамж илэрхийлсэн аялал болон хөдөө орон нутагт ажиллахдаа бомбор /куртика/ өмсөж байна.



3. Ажилтнуудын санаачлагаар 1 болон 2 даврхын үйлчилгээний зааланд цайны булан байгуулахыг байгууллагын зүгээс дэмжиж кофе чанагч болон бусад зүйлээр дэмжиж ажилласан.



5. Нийгмийн хамгааллын ажилтны өдрийн тохиолдуулан спортын 3 төрөлт тэмцээний арга хэмжээг зохион байгуулж, амжилттай оролцсон.



6. Газрын урд талын битүү хайс хамгаалалтыг Улиастай сумын ЗДТГазраас зөвшөөрөл авч иргэд тойрохгүй гарах нөхцөл боломжийг бүрдүүлж гарц хийж ажилласан.



7. Монгол Улсын ерөнхийлөгчийн 158-р дугаар зарлигийн дагуу зохион байгуулагддаг "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2025" хаврын номын баярын үйл ажиллагааг 2025 оны 05 сарын 14-ний өдөр тус аймагт зохион байгуулагдаж Баянхайрхан сумын нийгмийн даатгалын байцаагч, мэргэжилтэн Г.Туяа нь "Тэргүүний уншигч, үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэгчдийн уралдаан"-д амжилттай оролцож Тэргүүн байр эзэлсэн.



**ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТ, ШИМТГЭЛИЙН ӨР АВЛАГЫН БАРАГДУУЛАЛТ,
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТ, ТЭТГЭВЭР,
ТЭТГЭМЖ ОЛГОЛТЫН ТАЛААР**

2.1. Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт, шимтгэлийн өр авлагын барагдуулалт, нийгмийн даатгалын хамралтын талаар:



Аймгийн Татварын хэлтсээс 2023 болон 2024 онд шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгжийн судалгааны дагуу хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. Шинээр 39 аж ахуйн нэгж байгууллагын 93 иргэдийг албан журмын даатгалд хамруулсан байна. Албан журмын даатгалд шинээр хамрагдаж байгаа ихэнх ажил олгогчийн даатгуулагчийн тоо 1-2 байгаа учир шинээр хамруулах даатгуулагчийн тоо биелэхгүй байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 25 259 605.4 мянган төгрөг, гүйцэтгэл 25 310 909.6 мянган төгрөг 100.2 хувиар биелүүлсэн.

Шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сан тус бүрээр харуулбал:

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн сан	21 964 182	21 476 265.9	97.8
Тэтгэмжийн сан	1 838 718.5	2 091 327.1	113.7
Ажилгүйдлийн сан	623 914.1	730 185.4	117.0
ҮОМШӨ сан	832 790.8	1 013 131.2	121.7
Дүн	25 259 605.4	25 310 909.6	100.2

Орлогын бүтцийг авч үзэхэд 4 сангийн төлөвлөгөө нэр төрлөөрөө бүрэн биелсэн байна.

Сангийн зарлага сан тус бүрээр харуулбал:

Сангийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэврийн сан	64 026 346.8	62 213 839.3	97.2
Тэтгэмжийн сан	3 121 066.6	2 284 596.8	90.6
Ажилгүйдлийн сан	1 384 821.4	1 272 871.5	91.9
ҮОМШӨ сан	129 490.5	84 580.8	65.3
Дүн	68 659 725.3	66 395 888.4	96.7

Хариуцсан ажил олгогч руу утсаар болон биеэр уулзалт зохион байгуулж, шимтгэлийн өртэй ажил олгогчдод өрөө барагдуулах, алданги тооцох тухай, нийгмийн даатгалын сангаас ажилтнуудад тэтгэвэр, тэтгэмж олгохгүй тухай мэдэгдлийг хүргүүлэн ажиллаж байна.

Оны эхний НДШ-н авлагатай 197 байгууллагын 816200.9 мянган төгрөгөөс 149 байгууллагын 624871.5 мянган төгрөг буюу нийт авлагын 76.6 хувийг бүрэн барагдуулсан.

2024 оны Шүүхийн шийдвэртэй байсан 1 ажил олгогч буюу Жавхлант шим ХХК-ийн 5140.5 мянган төгрөгийн шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан.

31-90 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй ажил олгогчдод Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу өр барагдуулах албан мэдэгдлийг 35 ажил олгогчид хүргүүлж, 197 байгууллагад утсаар ярьж сануулан ажиллаж байна.

91-180 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй 29 ажил олгогчдын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай мэдэгдлийг хүргүүлэн дансыг түр хааж, үүнээс шимтгэлээ төлсөн 12 ажил олгогчийн дансны зарлагын гүйлгээг нээж ажилласан.

181-270 хоногийн насжилттай шимтгэлийн өртэй 2 ажил олгогчийн удирдлагатай уулзалт хийж авлага барагдуулах гэрээ байгуулсан.

271 ба түүнээс дээш хоногийн насжилттай шимтгэлийн өртэй 3 ажил олгогчийг хуулийн байгууллагад шилжүүлж, 6 ажил олгогчийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн ажилласан. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлсэн 2 ажил олгогчийн 1508.4 мянган төгрөгийн шимтгэлийн өр бүрэн барагдсан.

Ажил олгогч байгууллагын НД-7, НД-8 тайлан баталгаажуулахад тухайн сарын албан журмын даатгалын шимтгэлийн нэхэмжлэх 2 удаа үүсч, хаагдсан 10 байгууллагын тайланг цуцалж, дахин баталгаажуулж зассан.

Нийгмийн даатгалын 2024 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан. Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар 145759.8 мянган төгрөгийн зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн тайлант хугацаанд зөвлөмжид дурьдсан зөрчил гаргаагүй байна. Зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь <https://fas.audit.mn/>-д оруулан тайлагнасан.

Арилжааны банктай байгуулсан гэрээнд өдөр бүрийн үлдэгдэлд хүү тооцон 41713.6 мянган төгрөгийг хүүгээр бүртгэсэн. Тэтгэвэр тавьж олгосны банкны үйлчилгээний хөлсөнд 2626.5 мянган төгрөг шилжүүлсэн.

2.2. Тэтгэвэр, тэтгэмж олголтын талаар:

13136 тэтгэвэр авагчдад 62 213 839.3 мянган төгрөгийг тэтгэврийг хуульд заасан хугацаанд олгосон. Шинээр тэтгэвэр тогтоолгохоор өндөр насны 197 иргэн, хөдөлмөрийн чадвар алдсаны 37 иргэн, тэжээгчээ алдсаны 16 иргэн нийт 250 иргэн хүсэлтээ ирүүлж тэтгэвэр тогтоолгон авч байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 829 даатгуулагчид 2 284 596.8 мянган төгрөгийн тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас 305 даатгуулагчид 1 272 871.5 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон.

Шинэ систем нэвтэрч байгаатай холбоотой НДЕГ-аас зохион байгуулсан сургалтад хамрагдан байцаагч ажилтнуудын програм хангамж ашиглах видео хичээл бэлтгэн сумдын байцаагчдад цахимаар болон танхимаар мэдээллийг хүргэн ажиллаж байна.

Идэвхитэй тэтгэвэр авч байгаа тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэргийн тооллогыг хийх ажлын хэсгийг хагас бүтэн жилээр томилон 1 удаа тооллогыг хийсэн. Тооллогоор өндөр насны-10716, хөдөлмөрийн чадвар алдсаны-1503, тэжээгчээ алдсаны- 446, Цэргийн албан хаасны-327, ҮОМШӨД Сангаас тахир дутуу тэжээгчээ алдсаны-14, тэтгэврийн тусгай зохицуулалтын-130 нийт-13136 тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийг тэтгэврийн массивтай тулган шалгаж, ЗН-НД-6, ЗН-НД-7 маягтаар нэгтгэхэд тэтгэврийн хувийн хэрэг болон хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт бичиг дутагдсан зөрчил илрээгүй.

Шинээр тэтгэмж тогтоолгох болон тэтгэмж авахаар хүсэлт ирүүлсэн Хөдөлмөрийн чадвар алдсаны 237, ажилгүйдлийн тэтгэмж 305, жирэмсэн амаржсаний тэтгэмж 464, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмж 128 нийт 1134 даатгуулагчийн материалыг мэдээлийн баазад хянан оруулж, олголт үүсгэн тэтгэмж олгосон.

ГУРАВ: ГАМШГААС ХАМГААЛАХ МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ТАЙЛАН

2025 оны 03 сарын 26-ны өдөр Нийгмийн хамгааллын бүлгийн тушаал гишүүдийн тушаалыг шинэчлэн зохион гаргасан. Нийгмийн хамгааллын бүлгийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулан аймгийн онцгой байдлын газраар батлуулсан.

2025 оны 03 сарын 27-ны өдөр аймгийн онцгой байдлын газраас зарлан дуудах дохиог ажилуулж нийт нийгмийн хамгааллын бүлгийн бэлэн байдлыг шалгаж, баг бүрэлдэхүүн бэлэн жагссан.



ДӨРӨВ. МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН

Нийгмийн даатгалын газрын дэргэдэх маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга өндөр насны тэтгэвэрт гарсан, 1 гишүүн ажлаас чөлөөлөгдсөн үндэслэлээр салбар зөвлөлийн бүрэлдэхүүн 2 удаа шинэчлэн батлагдсан бөгөөд газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/12, Ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/140 дугаар тушаалуудыг тус зөвлөлийн гишүүдэд танилцуулан ажилласан.

Тус зөвлөл нь 2025 оны эхний хагас жилийн байдлаар Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн хурлыг 5 удаа хуралдуулж, 16 хүний өргөдлийг авч хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн асуудлаар-4

Малчнаар ажилласан жилээ тогтоолгох асуудлаар-12

Мөн тус зөвлөлийн хурлаас тогтоолоор-7, тоотоор 9 хүнд хариу өгч ажилласан.

Зөвлөлийн гишүүдэд Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон холбогдон гарсан зөвлөмж, зааврыг тухай бүр нь танилцуулан ажиллаа.



ТАВ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЛААР**Нийгмийн хамгааллын талаар:**

Тус газрын ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалтыг гүйцэтгэн, хугацаанд нь биелэлтийг хүргүүлэн ажилласан. Шалгалтаар 54 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрснээс ажилгүйдлийн тэтгэмжийг 26 даатгуулагчид 16,525.3 мянган төгрөг илүү, 8 даатгуулагчид 7,154.7 мянган төгрөгийг дутуу олгосон байна. Нийт 23,680.0 мянган төгрөгийн төлбөр зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоосон. Мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа албан журмын даатгуулагчаар шимтгэл төлж ажилласан 18 даатгуулагчийн ажилд орсон тушаал шийдвэрийг авч зөрчлийг арилгуулах тухай албан бичгийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэст хүргүүлсэн.

Эрсдэлийн үнэлгээний талаар: 2025 оны эхний хагас жилийн байдлаар их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагаас 19 байгууллага шалгаснаас 73 зөрчил илэрч 50 хувийг арилгуулсан байна. Дээрх илэрсэн зөрчлийг ангилан үзэхэд:

1. Ус хангамж, сувагжилт хог хаягдлыг хуримтлуулах, түгээх, зайлуулах, боловсруулах, ариутгах чиглэлээр 2 объект хамрагдаж эрсдэлийн түвшин бага, хууль сахин мөрдөлт 91 хувьтай байна.

2. Цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэх, түгээх дамжуулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 3 ажил олгогчийн эрсдлийн түвшин бага, хууль сахин мөрдөлтийн түвшин 88.8 байна.

3. Барилгын угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт төлөвлөгөөт 1, төвөллөгөөт бус 13 объектод хийсэн ба гүйцэтгэлийн шалгалтаар эрсдлийн түвшин тооцно.

Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/20 дугаартай тушаалаар мэдээлэл байршуулах болон хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилсон.

2025 оны эхний хагас жилийн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг “shilen.gov.mn”-д хуульд заасан хугацаанд байршуулсан.

2025 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд “Шилэн дансны хууль” болон “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу тайлант хугацаанд тусгай зориулалтын сангийн мэдээллийг 68 удаа мэдээлэхээс хугацаандаа 68, газрын үйл ажиллагааны зарцуулалтын мэдээллийг 73 удаа мэдээлэхээс хугацаандаа мэдээлсэн 73 байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй ба бүрэн мэдээлсэн.

Тус газарт бүртгэлтэй ажил олгогчийн 30 хувийг хамруулан шалгахаар удирдамжийг батлуулсан. Удирдамжийн дагуу шалгалтыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд шалгалтын хугацаа 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл явагдана.

2025 оны эхний хагас жилийн байдлаар 7 ажил олгогчийн 11 даатгуулагчтай холбоотой хугацаандаа төлөгдөөгүй 3,408.5 мянган төгрөгийн шимтгэл болон түүнд ногдох алдангийг “Зөрчлийн талаарх гомдол, мэлээллийг хүлээн авахаас татгалзсан материал” хүлээн авч шийдвэрийг Прокурорын байгууллагаар хянуулан хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлсэн. “Зөрчлийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.17.4 дэхь заалтын дагуу 4 ажил олгогчид 1,000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэн төлбөрийг бүрэн барагдуулсан. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт ханган ажиллаж байна.

Нийт 18 ажил олгогчийг шалгаж 22 даатгуулагчтай холбоотой 3,796.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоон 3,796.5 мянган төгрөгийг барагдуулан актын биелэлт 100 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гурван их дээд сургууль, коллеж байгаа бөгөөд 2 ажил олгогчийн 2020-2024 оны санхүүгийн баримтыг бүрэн шалгаж дууссан.

1.Хөгжим бүжгийн коллеж нь 2024 онд 4 даатгуулагчтай холбоотой хүүхдээ асрах чөлөөтэй байгаа хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тайлагнаагүй орхигдуулсан зөрчил илэрсэн. Гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах хэрэг үүсгэн прокурорын байгууллагаар хянуулахаар хүргүүлэн ажилласан. Мөн тус ажил олгогч нь 9 даатгуулагчтай холбоотой төрлийн кодыг буруу тайлагнасан ба шалгалтын явцад холбогдох журамд заасны дагуу залруулах арга хэмжээ авч ажилласан.

2.НДЕГ-ын Дотоод аудит мониторингийн газрын даргын 2025.05.21-ны өдрийн 02/1270 тоот албан бичгийн дагуу хийгдэж буй хяналт шалгалтын ажлыг 10 дугаар сард шалгаж дуусгахаар түр зогсоосон.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар:

НДЕГ-ын даргын 2023 онд баталсан удирдамжийн дагуу 2017-2022 оныг дуусталх хугацааны тус газрын сангийн болон хэлтсийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд үндэслэлгүй баримт бичиг бүрдүүлэн шүүхийн шийдвэр гаргуулж тэтгэвэр тогтоолгон авсан 46 иргэнтэй холбоотой 507,578,0 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын байцаагчийн алдааны улмаас шалтгаалан 16 иргэнтэй холбоотой 23,707.8 мянган төгрөгийн, нийт 531,286.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.НДЕГ-ын даргын 2023 оны А/69 дүгээр тушаал “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай”-ын дагуу 7 арга хэмжээ 27 ажил үйлчилгээ бүхий төлөвлөгөө хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлбөр

зөрчлийг барагдуулах Улсын байцаагчийн үйлдсэн төлбөр зөрчлийн актаас 351,757.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 66,2 хувьтай байна.

НДЕГ-ын даргын 2024 онд баталсан удирдамжийн дагуу хийгдсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 2 даатгуулагчтай холбоотой 38,970.4 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоосон.

2025 оны эхний хагас жилийн байдлаар НДЕГ-ын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 570,257.2 мянган төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 351,757.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 61,6 хувьтай байна.

Аймгийн Санхүүгийн хяналт,дотоод аудитын албанаас 2023 онд тус газрын 2020-2021 оныг дуусталх хугацааны тус газрын сангийн болон хэлтсийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд 3,361.0 мянган төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоож 3,160.0 төгрөгийг барагдуулсан. Актын биелэлт 94 хувьтай байна.

Дотоодын хяналт шалгалтаар 49,313.6 мянган төгрөгийн төлбөрөөс 12,437.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 25,2 хувьтай байна.

ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН МАГАДЛАЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ТАЛААР:

Тус зөвлөл нь нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 10 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр нийгмийн даатгалын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, ЭММТөв зөвлөл ирүүлсэн зөвлөмж, чиглэлүүдийг хэрэгжүүлэн бичиг баримтанд үндэслэн, цахимаар болон иргэд даатгуулагчдыг байлцуулан хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох сунгах, цуцлах, хөдөлмөрийн нөхцөл солих, ажлын цаг богиносгох зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэн долоо хоног бүрийн пүрэв гаригт хуралддаг.

Тайлант хугацаанд 7 хоног бүрийн пүрэв гаригт нийт 19 удаагийн хурлыг зохион байгуулсан. 641 хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг магадалснаас 89 хүнийг шинээр тогтоож, 497 хүний сунгаж, 72 цуцалсан, 1 хөдөлмөрийн нөхцөл сольсон, 3 шилжиж явсан, 1 шилжиж ирсэн, 58 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг оношийн үндэслэл, оношлогоо, шинжилгээ хангалтгүй шалтгааны улмаас буцаасан шийдвэр гаргасан байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоолгосон 1652 хүн нийгмийн даатгалын сангаас, 1044 хүн нийгмийн халамжийн сангаас тус тус тэтгэвэр авч байна.

Хувь хэмжээгээр хагас (хэсэгчлэн) алдсан буюу 50-69 хувиар алдсан 1117, бүрэн алдсан буюу 70-100 хувьтай 1579 иргэн байна.

Даатгуулагч (иргэн)Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоох, сунгах, цуцлах, ажлын цаг богиносгох шийдвэрүүдийг гаргахдаа Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/441, А/192 тоот тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн мөрдөн ажиллаж байна.


2024 оны жилийн эцсийн байдлаар хөдөлмөрийн чадвар алдалттай 2719 тэтгэвэр авагч иргэн байсан нь өмнөх оны үлдэгдлээс 0.7 хувиар буурсан буюу 2699 тэтгэвэр авагч байна.

2025 оны эхний хагас жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгож, бүртгэгдсэн өвчлөлийн түвшингээр аймгийн хэмжээнд эхний 5 байранд зонхилон тохиолдож байгаа ХЧА-ын шалтгааныг авч үзвэл:

1.	Сэтгэц болон зан үйлийн эмгэг өвчин	644	23.9 хувь
2.	Гэмтэл согогийн өвчин	489	18.1 хувь
3.	Мэдрэлийн өвчин	380	14.1 хувь
4.	Дотрын өвчин	371	13.8 хувь
5.	Нүдний өвчин	315	11.8 хувь
6.	Бусад өвчлөл	500	18.3 хувь тус тус

эзэлж байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн өвчлөлийн байдлыг графикаар авч үзвэл



Засгийн газрын тогтоол 1, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаал 2, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон 3 албан тоот, зөвлөмж зааврыг тухай бүр болон эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдэд танилцуулан хэрэгжүүлэн ажилласан. Мөн 2025 оны эхний хагас жилийн байдлаар иргэдээс өргөдөл гомдол ирээгүй байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг цаг тухай бүрт нь Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн программд бүртгэн, хурал бүрийн дараа цахим эмнэлэг хөдөлмөрийн программд хурал бүрийн дараа мэдээллийн баазыг тавьж тэтгэвэр авагчдад чирэгдэл үүсгэлгүй ажилласан.

Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг батлан гишүүн тус бүрээс хийсэн ажлын тайланг хагас жилээр авч дүгнэв. Дүнгийн хурал дээр цаашид анхаарч ажиллах асуудлуудын талаар зөвлөлийн гишүүдтэй санал солилцон ажилласан.



“Завхан аймгийн Нийгмийн даатгалын газар” фэйсбүүкийн фэйж хуудсаар дамжуулан иргэдэд Засгийн газрын 448 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрмийн талаар мэдээллийг хүргэж даатгуулагч, иргэдийн асуултанд хариулан ажилласан.



Мөн 2025 оны 02 дугаар сард аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудад “Эмнэлгийн хуудас олгох, хянах” журмын талаар Google meet программ ашиглан сургалтыг хийсэн.



Архангай, Баянхонгор, Говь-алтай аймгуудын Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдтэй хамтран Ижил мэргэжилтний үзлэгийг зохион хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шийдвэрлэхэд бусад аймгийн ололттой тал бол, сул талын талаар хэлэлцэн анхаарах цаашид ололттой талуудыг ажилдаа тусган ажиллахаар болсон.



Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн байдалд дүн шинжилгээ хийсэн.

1. Завхан аймгийн Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийг нийт хүн амд харьцуулсан судалгааг гаргахад 3.8 хувь байна. 38.8 хувь нь Нийгмийн халамжийн сангаас 61.2 хувь нь Нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авч байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар 2715 байсан бол 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2695 болж өмнөх оноос 0.7 хувиар буурсан байна.

2. Өнгөрсөн 5 жилийн байдлаар Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хэмжээ тогтоолгосон иргэдийн хувь тогтмол буурсан үзүүлэлттэй байсан. Өвчний ангиллаар эхний 5 байрыг авч үзвэл Сэтгэц болон зан үйлийн эмгэг, Гэмтэл согогийн өвчин, Мэдрэлийн өвчин, Дотрын өвчин, Нүдний өвчин байна.

3. Сум тус бүрээр өвчний ангиллаар авч үзсэн судалгааг гаргасан.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоолгосон 1652 хүн нийгмийн даатгалын сангаас, 1044 хүн нийгмийн халамжийн сангаас тус тус тэтгэвэр авч байна.

Хувь хэмжээгээр хагас (хэсэгчлэн) алдсан буюу 50-69 хувиар алдсан 1117, бүрэн алдсан буюу 70-100 хувьтай 1579 иргэн байна.

Дээрх судалгаанууд дээр үндэслэн хөдөлмөрийн чадвар алдалтанд хүргэж буй өвчлөлүүдээс урьдчилан сэргийлэх, өвчилсөн тохиолдолд хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэхгүй байхад анхааран ажиллах. Манай аймгийн хувьд Ахуйн осол, үйлдвэрлэлийн осолд өртсөн даатгуулагч, иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээ болон хяналт муу байдагтай холбоотой хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгох иргэд их байна гэж үзэж аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн нэгдсэн эмнэлэг, сумын засаг дарга нар болон эрүүл мэндийн төвүүдэд албан бичгүүдийг хүргүүлэн ажилласан.

Сургалтууд

1. 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр магадлагч эмч Google meet программ ашиглан аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудад Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож буй засгийн газрын тогтоол, Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 42 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.

2. 2025 оны 02, 05 дугаар сард Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газартай хамтран 2 удаагийн “Авлигын шалтгаан нөхцөл, хор хөнөөл, гэмт хэрэг түүнээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад зөвлөлийн 10 гишүүн оролцсон.

3. 2025 оны 05 дугаар сарын 12,13-ны өдрүүдэд Улаанбаатар хотод болсон “Нүдний өвчний орчин үеийн оношилгоо, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтооход анхаарах асуудлууд” сэдэвт сургалтанд магадлагч эмч хамрагдсан.

4. Биндэргарав, Дөрвөн оноо ӨЭМТөвүүдийн эмнэлгийн хуудас эрх бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эмнэлгийн хуудас олгох, хянах” журмын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 10 эмч, мэргэжилтэн оролцсон.

5. Завхан аймгийн Нийгмийн даатгалын газрын фэйсбүүк фэйж группээр дамжуулан иргэдэд “Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн дүрэм” талаар сургалтыг зохион байгуулсан.

ДОЛОО. СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР

Сургалт сурталчилгааны тоон тайлан

Д/д	Хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээ	Ажил үйлчилгээний тоо	Хамрагдсан даатгуулагчийн тоо /давхардсан тоогоор/
1	Ажил олгогчид зориулсан сургалт	16	328
2	Гар утасны аппликейшн суулгасан тоо	1	125
3	Нээлттэй хаалганы өдөрлөг	2	129
4	Явуулын үйлчилгээ	76	4991
5	Газрын байцаагч ажилтнуудад зориулсан сургалт, зөвлөгөөн	19	245
6	Фэйсбүүк хуудасны хандалт, дагагчийн тоо	191	65200

1. Тус газрын 2025 онд албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшлүүлэх НДЕГазар, АЗДТГазар, Цагдаагийн ерөнхий газар, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Хүний эрхийн комисс, Прокурорын газраас зохион байгуулсан 19 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 245 ажилтанг цахимаар болон танхимаар хамруулсан.

2. Ажил олгогч иргэд даатгуулагчдад зориулсан сургалтыг 94 удаагийн сургалтаар 5448 иргэд даатгуулагч хамруулсан. Үүнд:

1. Нээлттэй хаалганы өдөрлөг 2 удаа, хүний тоо 129
2. Явуулын үйлчилгээ 76 удаа, хамрагдсан хүний тоо 4991

3. Газрын сошиал хуудас, веб хуудсаар постер мэдээлэл бэлтгэн түгээсэн 191 удаа, хүний тоо 65200, дагагч 4033

Байцаагч ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр

Шинэ ажилтнуудад зориулсан сургалт




Нийт байцаагч ажилтнуудад зориулсан сургалт



Ажлын байрны чанар стандартыг хэрэгжүүлэх нэвтрүүлэх сургалт



Шинэ ажилтнуудын сургалт-2



Шүүхийн тамгын газраас сургалт зохион байгууллаа



МУБИС-ын багшлах эрхийн сургалтад 2 ажилтнаа хамруулсан



Шудрага өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар



Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн нэмэлт өөрчлөлт



Абле програм хангамжийн сургалт



Ажил олгогч, даатгуулагч нарт зориулсан сургалт

Даатгалтай ирээдүй сургалт “Дэвшил сургууль”-ын 11 дүгээр анги



Даатгалтай ирээдүй сургалт “МУИС”-ын лицей 11-12 дугаар анги



14 хоног тутамд тогтмол лайв хийж байна

Завхан аймгийн нийгмийн даатгалын газар

“АЖИЛ ОЛГОГЧ ШИНЭЭР БҮРТГҮҮЛЭХ, ДААТГУУЛАГЧИЙН ТӨРӨЛ, ШИМТГЭЛ НОГДУУЛАХ ОРЛОГО” СЭДВЭЭР МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭНЭ

 Хяналт шалгалтын байцаагч Э.Рэнжиндорж

 Хамралт, өрлого шимтгэлийн өр хариуцсан байцаагч, мэргэжилтэн Б.Гомборагчаа

2025.04.25-ны 15:00 цагаас

 LIVE

Завхан аймгийн нийгмийн даатгалын газар

“НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛАХ ӨВЧНИЙ ТЭГТЭВЭР, ТЭТГЭМЖ, ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУҮЛЬ, АЖИЛ ОЛГОГЧИД ҮЗҮҮЛЭХ ШИМТГЭЛИЙН ХӨНГӨЛӨЛТ, ЧӨЛӨӨЛӨЛТ” СЭДВЭЭР МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭНЭ


 Хяналт шалгалтын байцаагч Э.Рэнжиндорж

 Магадлагч эмч мэргэжилтэн А.Цэрэнлхам


2025.04.28-ны 15:00 цагаас

 LIVE

Прокурорын газарт сургалт зохион байгууллаа.



Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтарсан уулзалт хийв





Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын харъяа агентлагуудын дунд тэмцээн зохион байгуулж амжилттай оролцлоо



ОУ-ын хөдөлмөрийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад мэдээлэл хийж зөвлөгөө өглөө



Малчны хотонд “Алдархаан сум”



Алдархаан сум “Багийн нийтийн хурал”



Цагаанхайрхан сум “Багийн нийтийн хурал”



Тэс сум “Эрүүл мэндийн төв, сургуулын ажилтнуудын сургалт”



Цэцэн-Уул сум “Багийн нийтийн хурал”



Идэр сум “Багийн нийтийн хурал”



Тэлмэн сум “Багийн нийтийн хурал”



Шилүүстэй сум “Багийн нийтийн хурал”



Завханмандал сум “Малчдын зөвлөгөөн”



Дөрвөлжин сум “Багийн нийтийн хурал”



НАЙМ. АЖИЛТНУУДЫН НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ТАЛААР

Албан хаагчдын нийгмийн баталгааг гангах 11 заалт бүхий төлөвлөгөөг Аймгийн Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн бөгөөд:

1. Албан хаагчдад хоол унааны мөнгийг зохих журмын дагуу сар бүр тооцон олгож байна.
2. 15 албан хаагчийн Зэрэг дэв ахиулах, шинээр авах саналыг хүргүүлж, шийдвэрлүүлсэн.
3. Газрын 1, 2 дугаар давхрын үйлчилгээний зааланд албан хаагчид цайны булан байгуулсан
4. Яамны болон Ерөнхий газрын шагналд 3 албан хаагчийг тодорхойлж шийдвэрлүүлсэн
5. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан
6. Салбарын болон аймгын тамгын газраас зохион байгуулсан сургалт, уулзалтад албан хаагчдыг хүрэн хамруулдаг
7. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 1 албан хаагч шалгаран “Орон сууцны хөнгөлөлт”-д хамрагдан 20.0 сая төгрөгийн хөнгөлөлтөнд хамрагдсан
8. Ажилтан өөрөө болон түүний ар гэрт зайлшгүй нөхцөл байдал гарсан болон 3 дугаар шатлалын эмнэлэгт онош тодруулах, нарийн шинжилгээ хийлгэх тохиолдолд төрийн албаны тухай хууль, хөдөлмөрийн дотоод журмыг үндэслэн 12 албан хаагчид цалинтай чөлөө олгосон.
9. Монголын үндэсний уламжлалт цагаан сарын баяраар газрын харъяа 15 ахмад настанд 750 000 төгрөгийн хүндэтгэл үзүүлсэн зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Ажилтан албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөгний хэрэгжилт 81.8 хувьтай байна. Хэрэгжих хугацаа бологүй 2 арга хэмжээ байна.

ДУГНЭЛТ

Тайлангийн хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан зорилтууд хэрэгжиж, шинэ хуулийн үйлчлэлээр тэтгэвэр тэтгэмж авах иргэдийн тоо өсч, өр авлагыг барагдуулах аяны хүрээнд оны эхний хуримтлагдсан шимтгэлийн авлагын 30-с доошгүй хувийг төлүүлж ажиллахаас 76.5 хувийг бүрэн төлүүлж, шимтгэлийн авлагатай аж ахуй нэгж байгууллагын тоог бууруулж амжилттай ажилласан.

Иргэд даатгуулагчдад хүргэх үйлчилгээний чанар , иргэдийн цахим үйлчилгээ, мэдээ мэдээллийг хүлээн авах чадвар дээшилж бүх архивын лавлагаа, эмнэлгийн хуудас цахим хэлбэрт шилжсэнээр бүх төрлийн цахим үйлчилгээ авсан иргэдийн тоо өссөн байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас цахимаар зохион байгуулж буй бүх төрлийн сургалтууд, сумдын байцаагчдыг чадавхжуулах сургалт үр дүнтэй байж, авлага барагдуулах, сайн дурын даатгалын хамралт, сургалт сурталчилгааны шинэ арга барил, Засгийн газрын 1111 төвд ажиллаж иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж байгаа туршлага шинэ санааг өгсөн Ерөнхий газрын Удирдлагын багтаа талархал илэрхийлье.

ТАЙЛАН БИЧСЭН:

ГАЗРЫН ДАРГА

С.НЯМЖАВ